Сувилагч нарын мэдээлэл зүйн чадамжид нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох нь

Д.Дэлгэр[1], О.Сувд-Эрдэнэ[1], Г.Хулан[2]

[1]ГССҮТ, Сувилахуйн алба
[2]АШУҮИС, Сувилахуйн сургууль, НЭМСТ
Цахим шуудан: dddelger28@gmail.com, Утас: 88291099

Түлхүүр үг:
Мэдээлэл зүйн чадамж
Мэдээлэл зүйн мэдлэг
Компьютерын суурь ур чадвар

Товч утга:
Үндэслэл: Орчин үед мэдээллийн технологи нь манай эрүүл мэндийн салбарын чухал хэсэг бөгөөд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдээс тусламж үйлчилгээ үзүүлэх технологийг удирдах, ашиглахад компьютерийн анхан шатны мэдлэг, мэдээллийн технологийн ур чадвартай байхыг шаардсаар байна. Эрүүл мэндийн мэдээллийн технологи нь бүх шатны эмнэлгүүдэд цахим хэлбэрт хүч түрэн орж, цахим системд шилжсэнтэй холбоотойгоор цахим программд өвчтөний бүх төрлийн дата өгөгдлийг өгөгдлийн санд оруулах, цахим программ технологийг ашиглаж сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлэхэд сувилагч нараас мэдээлэл зүйн ур чадвар, чадамжийг ихээр шаардах болсон. **Зорилго:** Сувилагч нарын мэдээлэл зүйн чадамж, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох. **Арга, аргачлал:** Бид судалгааг агшингийн судалгааны загвараар, боломжит түүврийн аргаар ГССҮТ, ХӨСҮТ, УБТЗ-ын 3 эмнэлэгээс цахим программ хэрэглэдэг 233 сувилагчийг түүвэрлэн, мэдээллийг цуглуулсан. Сувилагч нарын мэдээлэл зүйн чадамжийг үнэлэх хэрэглэгдэхүүн нь 48 асуулт, 5 дэд бүлгээс бүрдэнэ. SPSS-25.0 программд статистик ур дүнгийн боловсруулалт хийж дескриптив статистик, корреляцын хамаарлын дүн шинжилгээ, болон регрессийн шинжилгээгээр ур дүнг тооцлоо. **Үр дүн:** Судалгаанд оролцогчдыг насны бүлгээр авч үзэхэд 20-29 насныхан 31.3%, дундаж нас 36.0±9.4 жил байв. Компьютерын хэрэглээний хувьд өдөрт хэд хэдэн удаа 73.4% (n=171), компьютер ашиглалт нь 2-оос илүү цаг 81.5% (n=190) ашигладаг ур дүн тодорхойлогджээ. Сувилагч нарын мэдээлэл зүйн чадамж 51.1% нь харьцангуй сайн гэж тодорхойлогдлоо. Сувилагч нарын мэдээлэл зүйн чадамж нь боловсролын зэрэг, настай сул хамааралтай байна. Компьютер ашиглалтын хувьд нас ($r=-0.150$, $p=0.02$) нь сөрөг сул хамааралтай, боловсролын зэрэг нь ($r=0.223$, $p=0.01$) сул хамаарал бүхий статистик $p\leq0.05$ ач холбогдолтой байна. **Дүгнэлт:** Сувилагч нарын мэдээлэл зүйн чадамжийн түвшин 51.1% гэж дүгнэгдлээ. Сувилагчийн мэдээлэл зүйн чадамжид нөлөөлж байгаа хүчин зүйлс нь нас болон компьютерын хэрэглээ байгаа нь тодорхойлогдлоо.

Үндэслэл: Орчин үед мэдээллийн технологи нь манай эрүүл мэндийн салбарын чухал хэсэг бөгөөд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдээс тусламж үйлчилгээ үзүүлэх технологийг удирдах, ашиглахад компьютерын анхан шатны мэдлэг, мэдээллийн технологийн ур чадвартай байхыг шаардсаар байна. Сувилахуйн мэдээллийн чадамжийг мэддэг байх нь тэдний мэргэжлийн үүргээ биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай гэсэн нотолгоо байна. Мэдээлэл зүйн стандарт, чадваргүй бол мэдээллийн технологи нь эрүүл мэндийн салбарт ур дүнгүй болж, өвчтөний аюулгүй байдалд эрсдэл учруулах болно гэж онцлон тэмдэглэсэн байна.[1] Эрүүл мэндийн салбарт компьютер, мэдээллийн технологи гарч ирснээс хойш сувилахуйн мэдээлэл зүйн чадамжийг үнэлэх нь судлаачдын судлах чухал сэдэв болсон байна.[16]

Сувилахуйн мэдээлэл зүйн ажиллах хүчний судалгаагаар мэдээлэл зүйн сувилагч нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг харуулсаар байна. Цахим программыг

хэрэгжүүлсэнээр сувилахуйн клиник бичиг баримтын ачаалал 67% болж буурсан, мөн эмнэлгийн тусламж үйлчилгээний цэгүүд 44% болж нэмэгджээ. Сувилахуйн хүний нөөцөд шаардагдах мэдээллийн технологийн наад захын чадамжийг тодорхойлоход чиглэгдсэн технологийн мэдээлэлзүйн боловсролын шинэчлэлийн дагуу сувилагч бүр компьютерын үндсэн ур чадвар, мэдээллийн мэдлэг, эмнэлзүйн мэдээллийн менежменттэй холбоотой ур чадвартай байх ёстой болохыг судлаачид дурдсан байна.[17]

Манай улсад эрүүл мэндийн салбарт 38 төрлийн цахим программыг ашиглаж байгаа баримт байна.[18] Эрүүл мэндийн мэдээллийн технологи нь бүх шатны эмнэлгүүдэд цахим хэлбэрт хүч түрэн орж, цахим системд шилжсэнтэй холбоотойгоор цахим программд өвчтөний бүх төрлийн дата өгөгдлийг өгөгдлийн санд оруулах, цахим программ технологийг ашиглаж сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлэхэд сувилагч нараас мэдээлэл зүйн ур чадвар, чадамжийг ихээр шаардах болсон байна. Иймээс сувилахуйн мэргэжилтнүүдийн мэдээлэл зүйн чадамжийг үнэлж, хөгжүүлэх шаардлагатай талаарх судалгаа хомс байна.

Зорилго: Сувилагч нарын мэдээлэл зүйн чадамж, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох

Арга, аргачлал: Бид нэг агшингийн судалгааны загвараар ГССҮТөв, ХӨСҮТ, УБТЗ-ын эмнэлгээс боломжит түүврийн аргаар нийт 233 сувилагчийг хамруулсан. Судалгааны хэрэглэгдэхүүнд сувилагч нарын мэдээлэл зүйн чадамжийг үнэлэх нийт 48 асуулт, 5 дэд бүлгээс бүрдсэн асуумжийг ашигласан. Статистик боловсруулалтын SPSS-25.0 программыг ашиглан судалгааны хүн ам зүйн мэдээллийг дескриптив статистикаар дундаж утга, стандарт хазайлт, хувь, давтамжийг, үр дүнгийн нарийвчлал хоорондын хамаарлыг Пиарсоны корреляцийн шинжилгээ, таамаглагч хувьсагчийг олон шатлалт шугаман регрессийн шинжилгээгээр тус тус тооцсон. P<0.5 байхад статистик ач холбогдолтой гэж үзсэн.

Үр дүн: Судалгаанд хамрагдсан нийт 233 сувилагчдын дундаж нас 36.1±9.4 жил, эдгээрийн 92.7% (216) нь эмэгтэйчүүд байна. Боловсролын түвшингийн хувьд 60% (142) нь бакалаврын боловсролтой буюу, 20-иос дээш жил ажилласан 23.6% (55), мэргэжлийн зэрэггүй 58.4% (136) тус тус байв. Компьютерын хэрэглээний хувьд өдөрт хэд хэдэн удаа 73.4% (171), компьютер ашиглалтын хувьд ээлж бүрт 2-оос илүү цаг 81.5% (190) нь ашигладаг гэсэн байлаа. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн ерөнхий үзүүлэлт (n=233)

Үзүүлэлт		Давтамж	Хувь (%)
Нас (жил)	36.1±9.4		
Хүйс	Эрэгтэй	17	7.3
	Эмэгтэй	216	92.7
Боловсролын түвшин	Диплом	79	33.9
	Бакалавр	142	60.9
	Магистр	12	5.2
Мэргэжлийн зэрэг	Мэргэжлийн зэрэггүй	136	58.4
	Ахлах зэрэг	52	22.3
	Тэргүүлэх зэрэг	42	18
	Зөвлөх зэрэг	3	1.3
Ажилласан жил	1 хүртэлх жил	27	11.6
	1-5 жил	53	22.7
	6-10 жил	46	19.7
	11-15 жил	29	12.4
	16-20 жил	23	9.9
	20-с дээш жил	55	23.6
Компьютерын хэрэглээ	Өдөрт хэд хэдэн удаа	171	73.4
	Өдөрт 1 удаа	7	3
	7 хоногт хэд хэдэн удаа	43	18.5
	Сард хэд хэдэн удаа	12	5.2
Компьютер ашиглалт	1 цагаас бага	4	1.8
	1-2 цагийн хооронд	39	16.7
	2-оос илүү цаг	190	81.5

Сувилагч нарын мэдээлэл зүйн чадамжийн нийт дундаж оноо (μ±137.0), дэд бүлгээр харьцуулахад компьютерын суурь ур чадварын дундаж оноо (μ±48.9), мэдээлэл зүйн мэдлэгийн дундаж оноо (μ±43.7) байна. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Сувилагч нарын мэдээлэл зүйн чадамжийн түвшин (n=233)

Үзүүлэлтүүд	Нийт	Далайц	Дундаж утга	Стандарт хазайлт	Түвшин
Мэдээлэл зүйн мэдлэг	233	15-60	43.7	9.43	Сайн
Мэдээлэл зүйн ур чадвар	233	16-64	44.3	10.84	Сайн
Компьютерын суурь ур чадвар	233	20-68	48.9	11.27	Сайн
Мэдээлэл зүйн чадамж	233	60-189	137.	28.57	Сайн

Судалгаанд нийт оролцогч сувилагч нарын мэдээлэлзүйн чадамж 51.1% (119) байлаа. Сувилагч нарын мэдээлэл зүйн мэдлэг 53.6% нь “бүрэн чадамжтай” гэж тодорхойлогдлоо. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Сувилагч нарын мэдээлэл зүйн чадамж, дэд бүлэг, хувиар (n=233)

Чадамж	Компьютерын суурь ур чадвар	Мэдээлэл зүйн мэдлэг	Мэдээлэл зүйн ур чадвар	Нийт чадамж
Маш бага	0	1 (0.4%)	1 (0.4%)	0
Бага	32 (13.7%)	10 (4.3%)	42 (18%)	19 (8.2%)
Сайн	96 (41.2%)	97 (41.6%)	112 (48.1%)	119 (51.1%)
Бүрэн	105 (45.1%)	125 (53.6%)	78 (33.5%)	95 (40.8%)

Олон шатлалт шугаман регрессийн дүн шинжилгээнээс харахад нас болон компьютерын хэрэглээ нь сувилагчийн мэдээлэл зүйн чадамжид бие даасан, ач холбогдолтой нөлөөтэй хүчин зүйлс байна. Нас (β-.287 р p=0.032), байгаа нь нас 1 жилээр нэмэгдэхэд мэдээлэл зүйн чадамж 0.87 оноогоор буурч байна. Өөрөөр хэлбэл, залуу сувилагчид мэдээлэл зүйн чадамж харьцангуй өндөр байх хандлагатай. Харин компьютерын хэрэглээний түвшинтэй сөрөг хамаарал илэрсэн (β=–0.156, p=0.017) байна. (Хүснэгт 4)

Хүснэгт 4. Олон шатлалт шугаман регрессийн шинжилгээний үр дүн (n=233)

Үзүүлэлт	B	Стандарт алдаа	Beta	t	sig
Нас	-.869	.402	-.287**	-2.159	.032
Хүйс	-3.847	7.144	-.035	-.539	.591
Ажилласан жил	1.719	2.160	.104	.796	.427
Боловсрол	5.730	3.477	.112	1.648	.101
Мэргэжлийн зэрэг	2.984	3.126	.086	.954	.341
Компьютерын хэрэглээ	-4.625	1.926	-.156*	-2.402	.017
Компьютер ашиглалт	1.972	4.483	.029	.440	.660

Хэлцэмж: Бид энэхүү судалгаагаар сувилагчийн мэдээлэл зүйн чадамжид нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор судлаач, эрдэмтдийн судалгааны үр дүнтэй өөрсдийн үр дүнг харьцуулан судаллаа.

Mehrdad Farzandipour (2021) нарын судалгаагаар сувилагч нарын 66.5% нь компьютерыг харьцангуй сайн мэддэг гэжээ. Компьютер ашиглах давтамжийн хувьд дийлэнх нь (59%) өдөрт нэгээс олон удаа компьютер ашигладаг гэсэн бөгөөд ЭМ-ийн цахим системтэй харилцах харилцааны тухайд дийлэнх нь (59%) нь системтэй харьцахад нэг ээлжинд 1 цаг хүрэхгүй хугацаа зарцуулсан байна. 40 ба түүнээс дээш насны ихэнхи оролцогчид компьютерын мэдлэг багатай байв (P<0.02). Тиймээс нас, компьютерын мэдлэг, компьютерын үндсэн ур чадварын хооронд мэдэгдэхүйц хамаарал ажиглагдсан гэж тодорхойлсон байна.[1]

Hero Khezri (2021) нарын судалгаагаар сувилагч нарын мэдээлэл зүйн ур чадвар (62.98%), мэдээлэл зүйн мэдлэг (59%) байна. Хамгийн бага нь компьютерын суурь ур чадвар байна. Мэдээлэл зүйн ур чадварын бие даан ажиллах чадвар (r=0.27, p<0.001), нотолгоонд суурилсан үйл ажиллагаа, (r=0.55, p<0.001) болон эмнэлгийн мэдээллийн системд зарцуулсан цаг (r=0.16, p<0.01) зэрэгтэй эерэг хамааралтай байв. Судалгаанд оролцогчдын нас нь сувилагчдын мэдээлэл зүйн ур чадварт шууд бус бөгөөд чухал нөлөө үзүүлдэг болохыг энэхүү судалгааны үр дүн харуулж байна. Энэ нь бидний судалгааны үр дүнтэй ойролцоо байна. [2]

Aghazadeh-Asl (2017) нарын судалгаагаар эмэгтэй сувилагч нар эрэгтэйчүүдээс илүү CIRN оноотой байсан (p<0.027). Сувилагч нарын мэдээлэл зүйн чадамж болон эмнэлзүйн ур чадварын онооны хооронд дунд зэргийн чухал эерэг хамаарлыг харуулсан байна (r=0.341, p<0.001). Регрессийн шинжилгээний үр дүнд сувилагч нарын мэдээлэлзүйн чадамжийн онооны 11% нь сувилагч нарын эмнэлзүйн ур чадварын оноотой холбоотой болохыг харуулсан (P=0.001). Бидний судалгаанд хүйс болон боловсролын түвшин нь мэдээлэл зүйн чадамжтай хамааралгүй байсан нь энэхүү судалгааны үр дүнтэй ойролцоо байна.[5]

McGonigle, D (2022) нар нь нас нэмэгдэхийн хэрээр мэдээлэл зүйн чадамжийн оноо буурах хандлага илэрсэн нь залуу сувилагчид мэдээллийн технологид илүү дасан зохицсон, компьютерын суурь мэдлэг

болон дижитал орчинд ажиллах туршлага харьцангуй өндөр байж болохыг илтгэсэн байна. Энэ үр дүн нь мэдээлэл зүйн чадамж нь зөвхөн ажлын туршлагаас бус, технологийн орчинд суралцаж өссөн байдалтай холбоотой байж болохыг харуулж байна. Энэ нь мэдээлэл зүйн чадамж нь зөвхөн ажлын туршлагаас бус, технологийн орчинд суралцаж өссөн байдалтай нягт холбоотой байж болохыг тодорхойлсон байна.[12]

Мөн Gonen A (2020) нар нь компьютер болон мэдээллийн системийг тогтмол ашигладаг сувилагчдын мэдээлэл зүйн чадамж илүү өндөр байдаг болохыг тэмдэглэсэн бөгөөд сургалт, бодит хэрэглээ дутмаг байх нь чадамжийн хөгжлийг сааруулдаг гэж үзжээ. Энэ нь сувилагчдын мэдээллийн технологийн ур чадварыг системтэйгээр хөгжүүлэх сургалт, тасралтгүй боловсролын хэрэгцээ байгааг нотолж байгаа нь бидний судалгааны үр дүнтэй дүйцэж байна. Эсрэгээрээ хүйс, ажилласан жил, боловсролын түвшин, мэргэжлийн зэрэг, компьютер ашиглалт зэрэг хүчин зүйлс нь мэдээлэл зүйн чадамжид статистикийн ач холбогдолгүйг харуулсан энэ үр дүн нь өмнөх судалгааныудтай нийцэж байгаа бөгөөд мэдээлэл зүйн чадамж нь демографийн үзүүлэлтүүдээс илүүтэйгээр технологийн бодит хэрэглээ, дижитал ур чадвар, байгууллагын дэмжлэгтэй илүү нягт холбоотой болохыг харуулж байна.[13,14]

Дүгнэлт: Сувилагч нарын мэдээлэл зүйн чадамжийн түвшин 51.1% гэж дүгнэгдлээ. Сувилагчийн мэдээлэл зүйн чадамжид нөлөөлж байгаа хүчин зүйлс нь нас болон компьютерын хэрэглээ байгаа нь тодорхойлогдлоо.

Ном зүй:

1. *Farzandipour, M., Mohamadian, H., & Akbari, H. (2021). Designing a national model for assessment of nursing informatics competency. BMC Med Inform Decis Mak 21, 35. doi.org/10.1186/s12911-021-01405-0*
2. *Hero Khezri, Assessing nurse's informatics competency and identifying its related factors, 2019 Journal of Research in Nursing Doi: 10.1177/1744987119839453*
3. *Nursing Informatics Workforce Survey, 2020 May, Healthcare Information and Management Systems Society (HIMSS) available at: https://www.himss.org/resources/himss-nursing-informatics-workforce-survey*
4. *Medha Verna, (2019) Competency in informatics for nursing professionals in India:Imbibing the tech-culture among nursing professionals, January 2019 International Journal of Nursing Education 11(1) DOI:10.5958/0974-9357.2019.00015.1*
5. *Aghazadeh-Asl, E., Ghassemi, A. H., Bigdeli, Z., Soosani-Gharibvand, B., & Saki-Malehi,A. (2017). Surveying the information-seeking behavior and information need of nurses working in Ahvaz Hospitals affiliated with the Jundishapur University of Medical Science using an up-to-date Database. BMJ Open, 7(Suppl 1), bmjopen-2016-015415.116. doi.org/10.1136/bmjopen-2016-015415.116*
6. *Al-Hawamdih, S. and M. M. Ahmad (2018). "Examining the relationship between nursing informatics competency and the quality of information processing." CIN: Computers, Informatics, Nursing 36(3): 154-159.*
7. *Rawda Abdulla Ali, RN MN, Hamad Medical Corporation, Qatar, Review of Informatics Competencies Tools for Nurses and Nurse Managers, Canadian Journal of Nursing Informatics, 13(1), Winter 2018 http://cjni.net/journal/?p=5370*
8. *Anu-Marja Kaihlanen a, Kia Gluschkoff a, Ulla-Mari Kinnunen b, Kaija Saranto b, Outi Ahonen, Tarja Heponiemi a (2021) Nursing informatics competencies of Finnish registered nurses after national educational initiatives. 106, 105060. Available at:https://www.sciencedirect.com/science/article/pii/S0260691721003178#bb0195*
9. *Darvish, A., Bahramnezhad, F., Keyhanian, S., & Navidhamidi, M. (2014). The role of nursing informatics in promoting quality of health care and the need for appropriate education. Global journal of health science, 6(6), 11–18. https://doi.org/10.5539/gjhs.v6n6p11*
10. *Jouparinejad S, Foroughameri G, Khajouei R, Farokhzadian J. Improving the informatics competency of critical care nurses: results of an interventional study in the southeast of Iran. BMC Med Inform Decis Mak. 2020;20(1):1–12. https://doi.org/10.1186/s12911-020-01244-5.*
11. *Staggers, N., & Thompson, C. B. (2002). The evolution of definitions for nursing informatics: A critical analysis and revised definition. Journal of the American Medical Informatics Association, 9(3), 255–261. https://doi.org/10.1197/jamia.M1031*
12. *McGonigle, D., & Mastrian, K. G. (2022). Nursing informatics and the foundation of knowledge (5th ed.). Jones & Bartlett Learning.*
13. *Gonen, A., Sharon, D., & Lev-Ari, L. (2020). Nurses' information literacy skills and their attitudes toward computerized health information systems. Journal of Nursing Management, 28(4), 912–919. https://doi.org/10.1111/jonm.13009*
14. *Collins, S. A., Yen, P. Y., Phillips, A., & Kennedy, M. K. (2021). Nursing informatics competency assessment for the nurse leader: The Delphi study. Journal of Nursing Administration, 51(4), 195–201. https://doi.org/10.1097/NNA.0000000000000991*
15. *Kleib, M., Simpson, N., & Rhodes, B. (2019). Information and communication technology literacy of nurses: A cross-sectional survey. Journal of Nursing Education, 58(8), 432–438. https://doi.org/10.3928/01484834-20190719-04*
16. *Elsayed WA, Hussein FM, Othman WN. (2017) Relation between nursing informatics competency and nurses' attitude toward evidence-based practice among qualified nurses at Mansoura Oncology Center. International Journal of Nursing Didactics 7(6): 26–33*
17. *Darvish A, Bahramnezhad F, Keyhanian S, et al. (2014) The role of nursing informatics on promoting quality of health care and the need for appropriate education. Global Journal of Health Science 6:*
18. *Эрүүл мэндийн үзүүлэлт, 2023 он*

Factors Influencing Informatics Competencies Among Nurses

Delger D[1], Suvd-Erdene O[1], Khulan G[2]

[1]National Trauma Orthopedic Research Center of Mongolia
[2]Department of Public Health Nursing, School of Nursing, MNUMS
E-mail: dddelger28@gmail.com, Tel: +976-88291099

Abstract:
Background: In the modern era, information technology has become an integral component of the healthcare sector, increasingly requiring healthcare providers to possess basic computer literacy and information technology skills to effectively manage and utilize care delivery technologies. With the rapid digitalization of health information systems across all levels of healthcare facilities, there has been a transition toward electronic platforms, where comprehensive patient data are entered into databases and managed through digital applications. Consequently, the delivery of nursing care through electronic systems and technologies has placed growing demands on nurses to develop strong informatics skills and competencies.
Aim: To describe the informatics competency of nurses in Mongolia.
Materials and Methods: A cross-sectional design was used for the study. Data were collected from 233 nurses who use information technology. Study setting was taken from three hospitals including National Center for Traumatology and Orthopedics (NCTO), National Center for Communicable Diseases (NCCD), Ulaanbaatar Railway Hospital by using convenience sampling method. The self-assessment of Nursing Informatics Competency instrument for evaluating the informatics competence of nurses has 48 questions and is rated on a 1-4 Likert scale. Descriptive statistics, correlation analysis and multiple linear regression analysis were calculated using SPSS-25.0
Results: The quality of life among those with breast cancer was at a moderate level with the mean overall score of 58.8 (SD=13.08). The results of this study shown that the average age of subjects as (36±9.4) and 31.3% of participants were 20-29 years old. The majority of the subjects were 73.4% (n=171) use the computer several times a day, and 81.5% (n=190) use the computer more than 2 hours a day. 51.1% of nurses' informatics skills are relatively good. Multiple linear regression analysis revealed that age (β=–0.287, p=0.032) and computer use (β=–0.156, p=0.017) were significant predictors of total informatics competency among nurses. Increasing age was associated with a decrease in informatics competency scores. Other variables including gender, years of experience, education level, professional rank, and computer utilization were not statistically significant predictors.
Conclusion: The level of nurses' informatics competency was determined to be 51.1%. Age and computer usage were identified as significant factors influencing nurses' informatics competency.

Keywords*:* Informatics competency, Informatics knowledge, Basic computer skills